



**САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ**



Japan
Fund for
Poverty
Reduction

Төслийн дугаар: P44112-01
2014 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтийн тайлан

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ

Улаанбаатар хот
Санхүүгийн Зохицуулах Хороо

Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн баг 2013 онд “Хамтарсан ажлын хэсгийн санамж бичиг”, “Төсөл хэрэгжүүлэх заавар”, 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг удирдлага болгож дараах ажлуудыг гүйцэтгэв.

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1.** Товч танилцуулга
- 1.2.** Төслийн цаг хугацааны товъёог
- 1.3.** Төслийн зорилт
- 1.4.** Төслийн үр өгөөж
- 1.5.** Төслийн зардал, түүний ангилал

2. ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ БА МЕНЕЖМЕНТ

- 2.1.** Төсөл хэрэгжилтийн зохион байгуулалт
- 2.2.** Төслийн бүтэц болон баг

3. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1.ХЗХ-ДЫН ЗОХИЦУУЛАЛТБА ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЧАДАВХИЖУУЛАЛТ

(i) ХЗХ-ны зохицуулалт, хяналт шалгалт

(ii)ХЗХ-ны чадавхийн үнэлгээ, сургалт

3.2.МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ТУЛГУУРЛАСАН НАСАНД ХҮРЭГСДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

3.3.ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ХАНГАМЖ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ АЖЛУУД

- 4.1.1** ХЗХ-дын чадавхийг бэхжүүлэх хэсгийн хүрээнд
- 4.1.2** Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролын хүрээнд
- 4.1.3** Төслийн удирдлага, хангамж, мониторинг үнэлгээний хүрээнд

5. ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ

- 5.1.** Худалдан авалтын төлөвлөгөө
- 5.2.**Төслийн хүрээнд хийгдсэн гэрээнүүдийн жагсаалт

6. ЗАХИРГАА БА САНХҮҮ

- 6.1.** Төслийн үйл ажиллагааны зардал
- 6.2.** Төслийн урьдчилсан данс
- 6.3.** Төслийн санхүүгийн тайлан

ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛУУДЫН ЖАГСААЛТ

Нэрс	Байгууллага	Албан тушаал
Э.Энэрэлт	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Хөрөнгө оруулалтын эдийн засагч
Ж.Батцэнгэл	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Худалдан авалт хариуцсан ахлах мэргэжилтэн
Г.Цолмон	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Төслийн шинжээч
Н.Нарангэрэл	Сангийн яамны Төслийн хэрэгжилт, зохицуулалтын газар	Дарга
Х.Бум-Эрдэнэ	Санхүүгийн зохицуулах хороо	Ажлын албаны дарга
Н. Оюунчимэг	Санхүүгийн зохицуулах хороо	Бичил санхүүгийн газрын дарга
Ц.Мягмар-Очир	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв	Гүйцэтгэх захирал
Ш. Гоохүү	Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо	Захирал

ТОВЧЛОЛ БА ХУРААНГУЙ ҮГС

АХБ	Азийн хөгжлийн банк
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЯ	Сангийн яам
ХЗХ-д	Хадгаламж зээлийн хоршоод
ЯБЯС	Ядуурлыг бууруулах Японы сан
МҮХЗХХ	Монголын үндэсний хадгаламж зээлийн хоршоодын холбоо
МХСМТ	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТУХ	Төслийн удирдах хороо

ҮГСИЙН ТАЙЛБАР

text-in – радио, телевизээр цацсан мэдээллийн талаар болон асуултын хариултыг үүрэн утасны мессежээр хүлээн авах

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Товч танилцуулга

1. Азийн хөгжлийн банк (СЗХ)-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Сангийн яам (СЯ), Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны хооронд байгуулсан 2012 оны 1-р сарын 17-ны өдрийн “Санхүүжилтийн гэрээ”-ний дагуу нийт санхүүжилт 2,912,000 ам.доллар бөгөөд Японы Засгийн Газрын Ядуурлыг Бууруулах Японы Сан (ЯБЯС)-аас 2,5 сая ам.долларын буцалтгүй тусламжаар санхүүжигдэн хэрэгжихээр батлагдсан.

2. 2012 оны 6-р сарын 11-14-ний өдрүүдэд “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилготой АХБ болон СЗХ-ны хамтарсан ажлын хэсэг СЗХ дээр ажиллаж, төслийн баг, үндэсний болон ОУ-ын зөвлөхүүдтэй хамтран цаашдын үйл ажиллагааны чиглэлийг боловсруулсан.

3. АХБ-аас төслийн үйл ажиллагаанд дунд хугацааны үнэлгээг 2013 оны 10-р сарын 14-25-ны хооронд хийв. Энэхүү үнэлгээгээр (i) төслийн үр дүнг зорилгуудад харьцуулах; (ii) хэрэгжилтийн зохион байгуулалт, хүрээнд залруулга хийх, (iii) төсөлд учирч буй хүндрэл болон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг засан сайжруулах, (iv) төслийн үлдсэн хугацааны төслийн хэрэгжилтийн хуваарь, (v) төслийн зардал болон санхүүгийн төлөвлөгөө, (vi) бараа болон үйлчилгээний худалдан авалт, (vii) төслийн гүйцэтгэлийн дизайн мониторингийн хамрах хүрээний (DMF) үзүүлэлтүүд болон үнэлгээ (viii) төсөл хэрэгжих үлдсэн хугацаанд хийх ажлын хуваарилалт хийсэн. Ажлын хэсгийн уулзалтын хамтын ажиллагааны санамж бичигт СЯ, СЗХ, АХБ төслийн үлдсэн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцэн тохирсон асуудлуудыг тусгасан. Уг санамж бичиг 2013 оны 11-р сарын 17-ны өдөр 3 тал гарын үсэг зурж баталгаажсан.

1.2. Төслийн цаг хугацааны товъёог:

Японы Засгийн Газрын төсөл баталсан өдөр:	2010.11.09
АХБ-ны төсөл баталсан огноо:	2010.11.25
Буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурсан өдөр: (БТ-ийн хүчин төгөлдөр болсон хугацаа):	2012.01.17
Төсөл дуусгавар болох огноо:	2015.01.17
Төсөл эхлүүлэх ажлын хэсэг ажилласан өдөр:	2012.06.11-14
Төслийн харилцан ойлголцлын санамж бичигт өөрчлөлт оруулан, үйл ажиллагаатай танилцаж, төсөл шилжүүлсэн.	2012.11.21-22
Төслийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээ	2013.10.14-25

1.3. Төслийн зорилт

4. Төслийн зорилт нь хадгаламж, зээлийн хоршоо(ХЗХ)-дыг чадавхижуулах, салбарыг бэхжүүлэх, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар Монгол улсын ядуу болон эмзэг бүлгийн (амьжиргааны түвшингээс арай дээгүүр орлоготой хэдий ч эрсдэлд орж болзошгүй) иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Төслийн хүрээнд:

- (i) шинэ хууль, эрх зүйн дагуу ХЗХ-ны зохицуулалтууд, хяналт-шалгалтын системийн тогтолцоог сайжруулан нэвтрүүлнэ;
- (ii) газар дээрх үзлэг, шалгалт, тусгай зөвшөөрөл, ХЗХ бүрд үнэлгээ зэрэглэл тогтооно;
- (iii) ХЗХ-дын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сургалтын шинэ аргачлалыг нэвтрүүлнэ;
- (iv) насанд хүрэгчдэд санхүүгийн суурь боловсролыг телевизийн цуврал драм, үүрэн утасны мессежээр дамжуулан хүргэнэ;
- (v) гарч ирэх үр дүнг тодорхойлохдоо санамсаргүй түүвэрлэх аргаар нарийвчилсан үнэлгээ хийх болно.

5. Төсөл дараах үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- A. ХЗХ-дын зохицуулалт ба хяналт шалгалт; чадавхижуулалт
- B. Мэдээллийн хэрэгсэлд тулгуурласан насанд хүрэгчдэд зориулсан санхүүгийн боловсрол
- C. Төслийн удирдлага, хангамж, зохион байгуулалт ба үнэлгээ

6. Төслийг салбарын бодлого, эдийн засгийн асуудал, эрх зүйн зохицуулалт хариуцсан холбогдох Засгийн газрын эрх бүхий байгууллага, салбарын хөгжлийн бодлогын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлж байна.

1.4. Төслийн үр өгөөж

7. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн хэрэгжилт нь 2015 оны 1-р сарын 17-ны өдрөөр дуусгавар болно. Төслийг амжилттай хэрэгжүүлснээр гарсан үр өгөөж:

Хүснэгт 1. Бүрэлдэхүүн хэсгүүдээс хүлээгдэж буй үр өгөөж

Бүрэлдэхүүн хэсгийн нэр	Хүлээгдэж буй үр өгөөж
А бүрэлдэхүүн хэсэг	
ХЗХ-дын зохицуулалт ба хяналт шалгалт; чадавхижуулалт	<ol style="list-style-type: none"> 1. Зохицуулалтын журмуудад нийцсэн үйл ажиллагаа явуулдаг ХЗХ-дын эзлэх хувь хэмжээг 90%-д хүргэнэ. 2. Чадавхийн үнэлгээнд хамрагдах ХЗХ-дын эзлэх хувь хэмжээг 90%-д хүргэх ба холбогдох мэдээллээр ХЗХ-дын гишүүдийг хангасан байна. 3. ХЗХ-дын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ХЗХ-дын тэргүүлэгчдэд зориулсан олон хувилбар бүхий сургалтын аргачлалын үр өгөөж (суурь 0, зорилтот үр дүн: гурван аргачлалын аль нэг сургалтын аргачлал 50%-д хүрсэн байна) 4. ХЗХ байршдаг газар нутгийн хүн амын 50% нь ХЗХ-ны талаар суурь ойлголттой болж, найдвартай үйлчилгээгээр хангагдсан байна.
В бүрэлдэхүүн хэсэг	
Мэдээллийн хэрэгсэлд тулгуурласан насанд хүрэгчдэд зориулсан санхүүгийн боловсрол	<ol style="list-style-type: none"> 1. ТВ үздэг хүн амын 30% нь санхүүгийн боловсролын цувралыг үзсэн байна. 2. Санхүүгийн боловсролын талаархи асуултууд хариу явуулсан өрхийн 50% нь үнэн зөв хариулсан байна. 3. Үзэгчдийн тоо өндөр гарсан газар нутгийн ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өссөн байна.

	4. ХЗХ-дын гишүүд болон санхүүгийн боловсролын тухай телевизийн олон ангит цуврал үзэгч нарын ядуурлын түвшин 35%-аар буурсан байна.
С бүрэлдэхүүн хэсэг	
Төслийн удирдлага, хангамж, зохион байгуулалт ба үнэлгээ	<ol style="list-style-type: none"> 1. Зөвлөхүүд сонгон шалгарсан, ажил үүргээ гүйцэтгэсэн байна. 2. Санхүүгийн систем, НББ, санхүүгийн тайлагналт болон, хөндлөнгийн аудитын шалгалтад хамрагдсан байна 3. Төслийн жилийн төлөвлөгөө, зөвлөхүүдийн ажиллах хуваарь, хэрэгжүүлэлтийн тайлагналт системийг нэвтрүүлж өдөр тутмын хэрэгцээнд ашигласан байна 4. Мониторинг үнэлгээний систем нэвтрүүлэн хэрэгжүүлсэн, түүвэрлэлтийн аргаар хийх үнэлгээний ажлын зохицуулалт, дүн шинжилгээ, үр дүнгийн тайлан бүрэн гарсан байна.

1.5. Төслийн зардал, түүний ангилал

8. Уг төсөл нь 2.5 сая ам.долларын санхүүжилттэй, 3 жилийн хугацаатайгаар хэрэгжинэ. Санхүүжилтийн гэрээнд зааснаар, төслийн зарцуулалт нь зардлын ангиллаар хуваарилагдсан ба бүрэлдэхүүн хэсэг тус бүрт зөвлөхийн үйлчилгээ болон сургалтын зардал багтана.

Хүснэгт 2.Төслийн нийт санхүүжилтам.доллараар

	Төсвийн ангилал (Хэсэг тус бүрээр)	А хэсэг:	В хэсэг:	С хэсэг:	Нийт	Хувь
1	Тоног төхөөрөмж, бусад хангамжууд	114,000.0		30,000.0	144,000.0	6%
2	Сургалт, Семинар, Олон нийтэд зориулсан арга хэмжээ	224,720.0	396,000.0	19,000.0	639,720.0	26%
3	Зөвлөхийн үйлчилгээ	600,100.0	136,200.0	124,800.0	861,100.0	34%
4	Төслийн удирдлага			372,800.0	372,800.0	15%
5	Бусад: газар дээрхи санхүүгийн үнэлгээ, ХЗХ-дын чадавхийн үнэлгээ, хөндлөнгийн аудит	264,000.0	50,000.0	15,200.0	329,200.0	13%
6	Төлөвлөгөөгүй зардал	122,380.0	15,800.0	15,000.0	153,180.0	6%
	Дүн	1,325,200.0	598,000.0	576,800.0	2,500,000.0	100%
	Засгийн газрын оруулах хувь оролцоо	120,000.0	52,000.0	88,800.0	260,800.0	
	Бусад хувь оролцоо (ХЗХ-дын холбоо)	103,600.0			151,200.0	
	Нийт дүн	1,548,800.0	650,000.0	665,600.0	2,912 000.0	

Хүснэгт 3.Төслийн жил бүрийн зардал ам.доллараар

Зардлын нэр	2012	2013	2014	2015	Нийт
Төслийн хөрөнгө	677,497.76	1,326,465.49	470,686.75	25,350.00	2,500,000.00

оруулалтын зардал					
МУЗГ-ын үйл ажиллагааны зардал		44,801.69	29,259.98	7,168.84	81,230.52
Төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал	677,497.76	1,371,267.18	499,946.73	32,518.84	2,581,230.52

2.ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ ба МЕНЕЖМЕНТ

2.1. Төсөл хэрэгжилтийн зохион байгуулалт

9. ЯБЯС9152 МОН: “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төсөл нь ЯБЯС-ийн санхүүжилтээр АХБ, СЗХ-тай хамтран хэрэгжүүлэхээр төслийн баримт бичигт тусгагдсан.

Гүйцэтгэгч байгууллага

10. СЗХ нь ЯБЯС-ийн санхүүжилттэй “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх”төслийн хэрэгжүүлэгч агентлаг болно.

Хэрэгжүүлэгч байгууллагууд

11. Төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд нь СЗХ-ны Бичил санхүүгийн газар (БСГ), Монголын Хоршооллын Сургалт Мэдээллийн Төв (МХСМТ), Монголын Үндэсний Хадгаламж Зээлийн Хоршоодын Холбоо (МҮХЗХХ) болно.

Төслийн удирдах хороо

12. Төслийн удирдах хороо (ТУХ)-ны бүрэлдэхүүн нь СЗХ, МҮХЗХХ, МХСМТ болон Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо (МХҮНХ)-ны захирлын түвшний төлөөлөгчдөөс бүрдсэн. ТУХ нь төслийн хэрэгжилтийн ерөнхий удирдамж болон стратегийн чиглэлээр удирдлагаар хангаж ажиллаж байна. ТУХ-ны бүрэлдэхүүнд:

1. СЗХ-ны Ажлын албаны дарга бөгөөд ТУХ-ны дарга Х.Бум-Эрдэнэ,
 2. СЗХ-ны БСГ-ны дарга бөгөөд Төслийн захирал Н.Оюунчимэг,
 3. МҮХЗХХ-ны дарга Ш.Гоохүү,
 4. МХҮНХ-ны тэргүүлэгч гишүүн Ч.Алтангааяа
 5. МХСМТ-ийн гүйцэтгэх захирал Ц.Мягмар-Очир,
 6. Сангийн яам (СЯ)-ны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Түвшинжаргал,
 7. СЯ-ны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын мэргэжилтэн М.Аясгалан
13. 2014 оны эхний улиралд ТУХ 2 удаа хуралдаж 2014 оны үйл ажиллагааны тайлан, худалдан авалтын төлөвлөгөө, төслийн 2013 оны ажлын тайлан, уран сайхны киноны зохиол, студийн сонгон шалгаруулалт, уран сайхны кинонд өгөх үнэлгээний талаар хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргасан.

2.2. Төслийн бүтэц болон баг

14. Төслийг СЗХ бүхэлд нь удирдаж байна. Төсөл нь анхнаасаа төсөл хэрэгжүүлэгч нэгжгүй, харин СЗХ нь өөрсдийн хүчин чадалд тулгуурлан хэрэгжүүлэхээр төслийн багийг бүрдүүлэн СЗХ-ны БСГ-ын дэргэд байгуулсан. СЗХ-ны БСГ-ын дарга нь уг төслийн захирал бөгөөд түүний шууд удирдлага дор төслийн баг үйл ажиллагаа явуулж байсан. Төслийн дунд хугацааны үнэлгээ 3 талт Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу 2014 оны 1 дүгээр сараас эхлэн төслийн нэгж байгуулсан. Төслийн нэгж нь төслийн зохицуулагч, санхүү худалдан авалтын ажилтан, нарийн бичиг орчуулагч гэсэн 3 орон тоотой. Төслийн захирал нь төслийн хэрэгжилтийн хуваарьт хяналт тавьж, төслийг үр

дүнд чиглэсэн байдлаар ажлаа зохион байгуулж байна.

15. Төслийн нэгжийн ажилтнуудын сонгон шалгаруулалтаар төслийн нарийн бичиг болон орчуулагч, санхүү худалдан авалтын ажилтан 2014 оны 1 сард ажилдаа орсон ба төслийн зохицуулагч 2014 оны 2 сарын 4-ны өдрөөс ажилласан боловч цалингийн асуудлаас шалтгаалан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн. Төслийн зохицуулагчийн сонгон шалгаруулалтыг дахин зарлаж, шалгаруулах ажил хийгдэж байна.

16. Төслийн үйл ажиллагаанд мониторинг үнэлгээ хийх олон улсын багийг АХБ-ны суурин төлөөлөгчийн газраас сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулсан бөгөөд олон улсын зөвлөх 1 дүгээр сард 10 хоног Монгол ирж ажилласан. Тус багтай гэрээ хийсэн үндэсний зөвлөх мөн 9,5 сарын хугацаатай ажиллахаар ажилдаа орсон.

17. Олон нийттэй харьцах үндэсний зөвлөх болон санхүүгийн боловсролын үндэсний зөвлөхүүд засварлагатай байгаа хэдий ч санхүүгийн боловсрол олгох уран сайхны кинод санхүүгийн мессежүүдийг хэрхэн тусгах, үнэлгээ хэрхэн хийх, кино зохиол бичих, студи сонгон шалгаруулах даалгавар саналаа өгсөн болно.

3.ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 Бүрэлдэхүүн хэсэг А: ХЗХ-ДЫН ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ; ЧАДАВХИЖУУЛАЛТ

1.ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ

18. ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн талаар олон улсын зөвлөх Брайн Гэйтлийн өгсөн зөвлөмж, өгсөн зөвлөмж дээр үндэслэн газраас боловсруулсан журмын төслийн талаар 83 ХЗХ-дын 116 төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, сургалтыг Улаанбаатар, Эрдэнэт хотод зохион байгуулсан.
19. Олон улсын хяналтын зөвлөх Брайн Гэйтлийн өгсөн зөвлөмж дээр үндэслэн ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн журмын төслийг 2013 оны 11-р сарын СЗХ-ны хуралдаанд танилцуулж 2014 оны 1-р сарын хуралдаанаар батлуулсан.
20. Олон улсын зөвлөхүүдийн гаргасан зөвлөмж, мөрдөгдөж буй журамд өөрчлөлт оруулах талаар / газар дээрх хяналт шалгалт, тогтворжуулалтын сан, зохицуулалт/ хэлэлцүүлэг, сургалтыг Улаанбаатар хотын 37 ХЗХ-дын 73 ажилтан, сонгуультай нарт зохион байгуулсан.
21. Олон улсын зөвлөх Брайны өгсөн зөвлөмжийн дагуу ХЗХ-дын хяналт шалгалтын удирдамжинд өөрчлөлт оруулж, Өмнөговь аймгийн нэр бүхий 5 ХЗХ, Улаанбаатар хотын нэр бүхий 4 ХЗХ шалгалт хийсэн.
22. Хяналт шалгалт хийсэн тайланг нэгтгэн 1 хувийг Төсөлд хүргүүлсэн болно.
23. ХЗХ-дын нэвтрүүлэх нягтлан бодох бүртгэлийн программын ажлын даалгаврыг боловсруулах ажлыг хэсгийг томилсон ба ажлын хэсгээс ажлын даалгаврын төслийг гарган АХБ-д хүргүүлж, холбогдох саналыг тусган ажлын даалгаврыг эцэслээд байна.
24. ХЗХ-дын 2013 оны жилийн эцсийн тайлан балансыг шинэ системийн дагуу хүлээн авч нэгтгэн 140 ХЗХ-тайлангийн хариуг хүргүүлсэн.

2.ХЗХ-НЫ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ, СУРГАЛТ

1. Интернетэд суурилсан зайны сургалт

25. ХЗХ-дыг чадавхижуулахад сургалтын 2-3 аргыг туршихаар төслийн баримт бичигт тусгасны дагуу зайны сургалтын арга хэлбэрүүд болон Монголд тэдгээр арга хэлбэрүүдийг ашиглаж буй байдал, байгууллага тэдгээрийн туршлагын талаарх танадалтыг МХСМТ-ийн ажилтнууд гүйцэтгэсэн.
26. Энэхүү танадалтын үр дүнд үндэслэн ХЗХ-дод интернэтээр дамжуулан зайны сургалтыг явуулахаар шийдвэрлэж, сургалтыг “ХЗХ-ны зарчим ба засаглал” агуулгаар 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 2014 оны 1 дүгээр сарын 22-ныг дуустал 6 долоо хоногийн хугацаатай явуулсан.
27. Сургалтад Хэнтий, Төв аймгийн дараах ХЗХ-дын нийт 75 оролцогч хамрагдсан. Хоршоод нөөц гишүүд болон гүйцэтгэх албаны ажилтнуудаа сургалтад хамруулах хүсэлт гаргасан тул нийт оролцогсдын 19% нь нөөц гишүүд, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх албаны ажилтнаас бүрдсэн бөгөөд оролцогсдын дундаж нас 44,7 байсан.

Аймаг		Сум	ХЗХ-дын жагсаалт		Оролцогсдын тоо
1	Хэнтий аймаг	Батширээт	1.	Эг буман зоос	9
		Биндэр	2.	Сүлдэт өндөр	8
		Бор-Өндөр	3.	Өсөх өндөр	8
		Өмнөдэлгэр	4.	Зоос хүрд	10
2	Төв аймаг	Батсүмбэр	5.	Хас баяжих	9
		Борнуур	6.	Хас баян Өлзийт	10
		Жаргалант	7.	Эвт жаргалант	10
		Сүмбэр	8.	Сүмбэр гүн нуур	11

28. Сургалт нь танхимын сургалттай ижил агуулгаар явагдсан бөгөөд модулийг танхимын сургалтын хэлбэрээс интернэт сургалтад тохируулан хөрвүүлэх, сургалтыг хөтлөн явуулах үүргийг төслийн хүрээнд сургагч багшаар бэлтгэгдсэн

29. Нийт оролцогсдын хичээлийн идэвх оролцоог хэлэлцүүлэгт оролцсон байдал даалгавар ирүүлэлт, өөрийгөө шалгах сорил бөглөсөн байдлаар дараах хүснэгтэд хичээл тус бүрээр харууллаа.

№	Оролцоо	Хичээл 1	Хичээл 2	Хичээл 3	Хичээл 4	Хичээл 5	Хичээл 6
1	Хэлэлцүүлэг	33	47	46	31	39	39
2	Даалгавар	70	66	60	62	65	59
3	Сорил	52	63	57	66	53	
	Дундаж дүн буюу чанарын гүйцэтгэл	69%	70%	72%	82%	74%	70%

30. Сургалтын 6 хичээлийн туршид оролцогсдын дундаж оноо¹ 36,4 буюу 72,8%-тай байсан. Сургалтын 75 оролцогчийн 86,6% буюу 65 хүн 6 хичээлийн нийт даалгаврын 66,6% буюу 4-өөс дээш даалгаврыг хугацаанд нь ирүүлсэн нь оролцогсдын идэвх оролцоо өндөр байсныг харуулж байна.

31. Энэхүү интернет сургалтад оролцогсдын идэвх оролцоо, гүйцэтгэл, оролцогсдын өгсөн дүгнэлтээс харахад ХЗХ-дыг чадавхижуулахад интернэт сургалтын хэлбэрийг ашиглах нь үр дүнтэй болох нь харагдсан бөгөөд цаашид интернэтэд суурилсан сургалтыг явуулахад сургалтын модуль, агуулга, зохион байгуулалт, багш нарын чадвар туршлага зэрэгтэй холбоотой анхаарах асуудлыг тодорхойлж, “Интернетэд суурилсан зайны сургалтын тайлан”-д дэлгэрэнгүй тусгасан.

¹7 хоногт авах хамгийн өндөр оноо 50

2.ХЗХ-дын танхимын сургалт

32. Төслийн дунд хугацааны хяналтаар 2014 онд Улаанбаатар хотод 10, орон нутагт 16 сургалтыг танхимын хэлбэрээр явуулахаар шийдвэрлэсний дагуу 2014 оны 2 сарын 21-ний өдрөөс 3 сарын 30-ны хооронд Улаанбаатар хотод 9 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

33. Сургалтад Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 46 ХЗХ-ны 196 ажилтан, сонгуультан оролцсон. Ингэснээр Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 83,6 %, нийт гүйцэтгэх удирдлага сонгуультнуудын 48 хувь² нь “ХЗХ-ны зарчим ба засаглал” сургалтад хамрагдаад байна.

34. Үндэсний зөвлөх нь сургалтуудад мониторинг хийсэн бөгөөд энэ явцад багш нарын сургалт хийх гүйцэтгэл болон оролцогсдын идэвх оролцоо сайн, хөтөлбөр агуулга төлөвлөлтийн дагуу явагдаж байсан бөгөөд оролцогчид “ХЗХ-ны зохистой харьцааны болон дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт”-ийн журам 2014 оны 1 сарын 29-ний өдөр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сургалтын агуулгад энэхүү асуудлыг нэмэх саналыг тавьж байсан.

35. Иймд зарим сургагч багш нараас сургалтын хөтөлбөрт дээрх агуулгыг ОУ-ын ХЗХ-ны тогтвортой болон аюулгүй ажиллагааны журамтай уялдуулан нэмж холбогдох дасгал ажил, хууль журмуудтай холбоотой нэмэлт мэдээлэл өгөх нь зүйтэй гэсэн санал тавьсан тул сургалтын агуулгын хүрээнд уялдуулан өөрчилж, 3 сарын 14-16-ны өдөр шинэчлэн баяжуулсан агуулгаар туршилт хийж үзсэн.

36. МХЗХХ, МХСМТ болон сургалт багш нарын төлөөлөл 3 сарын 18-ны өдөр уулзалт зохион байгуулж, сургалтын агуулгад ЗХШҮ-ийг нэмэх, үүнтэй уялдаатай хөтөлбөрт зарим өөрчлөлтүүдийг оруулахаар шийдвэрлэж, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг М.Рита, Дэлгэрмаа, үндэсний зөвлөх Т.Оюунчимэг нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

37. Ажлын хэсэг нь 3 сарын 21-25-ны өдрүүдэд ажиллаж сургалтын материалд (презентаци, тараах материал, тест гм) орох өөрчлөлтийг цогцоор оруулж, 3 сарын 26-нд багш нарын төлөөллөөр хэлэлцэж, улмаар шинэчилсэн хөтөлбөрөөрх сургалтыг 3 сарын 28-30-нд хийсэн.

38. Хөтөлбөрт орсон өөрчлөлтийн талаар 3 сарын 31-ны өдөр МХЗХХ, МХСМТ, үндэсний зөвлөхүүд сургагч багшийн давтан сургалтыг хийсэн. Сургалтад хөдөө орон нутгийн сургалтыг явуулах Улаанбаатар хотын 15 багш оролцсон. Сургалтын материалуудыг нэгбүрчлэн эцэслэн хэлэлцэж, хэвлэлтэд хүлээлгэн өгсөн.

39. ХЗХ-дын үйл ажиллагаанд мөрдөх бодлого, журмын үлгэрчилсэн гарын авлагыг МХЗХХ-ны ажлын хэсэг болон Тэргүүлэгчдийн зөвлөл эцэслэн хянаж, 2014 оны 1 сарын 6-ны өдөр хэвлэлтэд хүлээлгэн өгсөн.

40. Нийт 334 хуудас бүхий 50 баримт бичиг боловсрогдон гарснаас АХБ санал болгосны дагуу төслийн удирдлага зөвшөөрч, НББ-ийн заавар аргачлал, НББ-ийн бодлогын хавсралтаар хийсэн дансдын жагсаалтыг хасч, ХЗХ-ны тухай хуулийг нэмснээр нийт 239 хуудас бүхий 50 баримт бичиг хэвлэлтэд бэлтгэгдсэн.

²2014 оны 2 сарын 14-ний байдлаар тусгай зөвшөөрөлтэй 55 ХЗХ УБ хотод үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд эдгээр ХЗХ-дын нийт тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийн тоо 198, хяналтын зөвлөлийн гишүүд 163, гүйцэтгэх захирал 46 байна.

41. Баримт бичгүүдийн электрон хувийг флаш дискээр, мөн хэвлэмэл байдлаар ХЗХ-дод өгч, ХЗХ-дын өөрийн онцлогт тохируулан батлан хэрэгжүүлж буйг ХЗХ-дын чадавхийн хойр дахь үнэлгээгээр үнэлэхээр тодорхойлсон.

42. Иймд төслийн нэгж нь хэвлэлийн компаниудын үнийн саналыг цуглуулж, сонгон шалгаруулалтын тайланг 2014 оны 2 сарын 11-ний өдөр явуулсан боловч хэвлэх шаардлагагүй гэсэн хариу АХБ-наас ирсэн. Улмаар нэмэлт тайлбарыг өгсний дараа 2 сарын 24-ний өдөр баримт бичгийг ном хэлбэрээр бус сургалтын материал байдлаар хэвлэх шийдвэрийг АХБ-наас өгсөн.

43. Төслийн нэгжээс холбогдох үнийн саналыг цуглуулан хэвлэлийн компанийг сонгож, хэвлэлийн эхийг бэлтгүүлж байна.

3.2 МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ТУЛГУУРЛАСАН НАСАНД ХҮРЭГСДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

44. Дэлхийн банкны судалгааны аргачлалын дүн шинжилгээ, фокус бүлгийн ярилцлага, судалгаа дээр мэдээллийн хэрэгцээг гаргаж, санхүүгийн боловсролын мессежийг түгээхэд шаардагдах зардал ба сувгийн хүртээмжийг тодорхойлсон.

45. Энэ мессежийг олон нийтэд хүргэх хүрээнд санхүүгийн боловсролын мессеж хүргэх телевизийн олон ангит киноны зохиолч сонгон шалгаруулах зарыг “Өдрийн сонин”, имэйл зараар иргэдэд хүргэсэн.

46. Зохиолчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан олон ангит зохиолын эхний 2 ангийг зохиолчоос хүлээн авч ТУЗ-ийн хуралд оруулж баталгаажуулсан.

47. Туршилтын 2 ангиар 3 студийн кино бүтээлгэхээр 12 студид урилга хүргүүлсэний дагуу 7 студийн хүсэлтийг хүлээн авч, үнэлгээний хороо үнэлгээ өгсөн боловч шаардлага хангаагүй тул ТУЗ-ийн хуралд танилцуулж, нийтэд зарлахаар шийдвэр гаргасан.

48. Телевизийн олон ангит киноны эхний 2 ангиар кино бүтээх студийг сонгон шалгаруулах зарыг “Өдрийн сонин” нийтлүүлсэн.

49. Энэ зарын дагуу нийт 14 студийн хүсэлтийг хүлээн авч, сонгон шалгаруулалтыг 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр хийхээр төлөвлөсөн.

50. ХЗХ-ны талаарх иргэдийн ойлголтыг сайжруулах, олон нийтэд зөв мэдээлэл өгөх зорилгоор ХЗХ-ны талаар 2,000 ширхэг брошур хэвлүүлж, ХЗХ-ны гишүүд, иргэдэд хүргээд байна.

51. Монгол улсад ХЗХ үүсэж, хөгжсөн түүхийг өгүүлсэн баримтат кинонажлын даалгавар боловсруулан, зарыг Өдрийн сонинд нийтлүүлсэн.

52. ХЗХ-ны хөгжлийн явц, өнөөгийн байдал, зохицуулалтын талаар товхимол бэлтгэн нийтэд хүртээл болгохоор боловсруулалт хийж байна.

3.3 ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ХАНГАМЖ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ҮНЭЛГЭЭ

53. Төслийн баг төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төслийн тусгай болон үйл ажиллагааны дансыг СЯ, АХБ-ны зөвшөөрөлтэйгээр Төрийн банкинд байршуулан ашиглаж байна. Төсөл хэрэгжүүлэх зааврын дагуу дансны хуулгыг АХБ-нд сар бүр хүргүүлж байгаа ба санхүүгийн болон төслийн хэрэгжилтийн тайланг АХБ, СЯ, Монгол дахь Японы элчин сайдын яам болон холбогдох хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагуудад улирал бүр хүргүүлж ажиллаж байна.

54. Төслийн үйл ажиллагааны талаарх танилцуулга хийх, шийдвэр гаргах зорилгоор тайлант улиралд нийт 2 удаа товлож ирцийг бүрдүүлэн хуралдуулж шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг шийдвэрлүүлснээс гадна үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан, хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагуудаас гаргасан ажлын саналуудыг тухай бүр ТУХ-ны даргад танилцуулан АХБ, СЯ-

аасзөвшөөрөл аван хэрэгжүүлж байна.

55. ТУХ-оос гаргасан ажлын удирдамжийн дагуу төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн төлөвлөгөөт ажлуудыг холбогдох байгууллагууд, зөвлөхүүдээс шаардан, хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэхэд ложистик ажиллагаагаар хангаж ажиллаж байна/Дэлгэрэнгүйг тухай бүрийн ТУХ-ны хурлын тэмдэглэлүүдээс үзэх боломжтой/.

56. Төслийн захирал төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, төслийн хэрэгжилтийн хуваарь, гүйцэтгэлийн байдлаар төслийн нэгжийн ажилтнууд, зөвлөхүүдээс танилцаж, үүрэг өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

57. Мониторинг үнэлгээний багаас эхлэлтийн тайлангаа 2014 оны 2 дугаар сарын 13-нд ирүүлсэн бөгөөд төслийн захирлын зүгээс эхлэлтийн тайланд санал өгсөний дагуу 2014 оны 3 дугаар сарын 29-ны өдөр тайлагаа эцэслэн ирүүлсэн.

58. Мониторинг үнэлгээний багийн ирүүлсэн тайлан шаардлага хангахгүй, ажлын даалгаврын хүрээнд юу хийх нь мэдэгдэхгүй, асуудалд цаг хугацаанд нь бодиттой хандахгүй байгаа зэрэг нь цаашид энэ баг төслийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, төслийн үйл ажиллагааг шуурхай, тогтвортой үргэлжлүүлэн явуулахад сөрөг нөлөөлөл гаргахаар байна.

59. Иймээс үндэсний зөвлөх дангаараа дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Үүнд:

- ✓ төслийн баримт бичигт тусгагдсан мониторинг үнэлгээний үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байна.
- ✓ ХЗХ-дын чадавхийн үнэлгээ, сургалт дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ХЗХ-ны чадавхийн үнэлгээний системтэй уялдуулж ХЗХ-дын үнэлгээ, сургалтын үнэлгээг хэрхэн хийх талаарх арга зүйг боловсруулан төсөл байдлаар танилцуулахаар бэлтгэж байна. “ХЗХ-ны чадавхийн үнэлгээний систем”, “ХЗХ-ны чадавхийн үнэлгээний аргачлал”-ын дагуу нийт 135 ХЗХ-дод хийсэн эхний шатны чадавхийн үнэлгээг дараагийн шатны чадавхийн үнэлгээний үр дүнтэй харьцуулж дүн шинжилгээ хийнэ.
- ✓ Эхний ба дараагийн шатны ХЗХ-ын чадавхийн үнэлгээний үр дүнг харьцуулсан дүн шинжилгээн дээр суурилж мониторинг үнэлгээний баг тодорхой бус байгаа зарим үзүүлэлтүүд дээр шаардлагатай мэдүүлүүдийг нэмж цуглуулахаар төлөвлөж байна.
- ✓ Нийт ХЗХ-дод хийсэн эхний болон төгсгөлийн шатны чадавхийн үнэлгээн дээр суурилж нийт ХЗХ-дод хийсэн сургалтын үр дүнг тодорхойлно. Сургалттай холбоотой нэмэлт мэдээллийг ХЗХ-доос цуглуулна.
- ✓ Мониторинг Үнэлгээний үндэсний зөвлөх Улаанбаатар хотын зарим хоршоодод зохион байгуулагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зарчмууд ба засаглал, туршлага” сургалтад хоёр удаа оролцож сургалтын үнэлгээтэй холбоотой шаардлагатай мэдээллийг авсан.
- ✓ Сургалтын үнэлгээнд ашиглах зорилгоор оролцогчдоос авах сургалтын өмнөх шалгах тестийг түүвэрлэж боловсруулан 4 дүгээр сард орон нутагт явагдах нийт сургалтад ашиглахаар сургагч багш нарт өгөв. Сургалтад оролцогчдоос авсан сургалтын өмнөх шалгах тестийг сургалтын дараах шалгах асуултуудынүр дүнтэй харьцуулан нэгтгэж сургалтын үнэлгээнд ашиглана.
- ✓ Сургалтын үнэлгээнд ашиглах зорилгоор төслийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн бүх сургалтын үнэлгээний хуудас, оролцогчдоос авсан мэдлэг шалгах тест, тайлан зэрэг мэдээллүүдийг цаасан болон цахим боломжит хэлбэрээр үндэсний зөвлөх Т. Оюунчимэгээс хүлээж авсан. Мониторинг үнэлгээний үндэсний зөвлөх хүлээж

- авсан бүх үнэлгээ болон тестүүдийг нэгтгэх, боловсруулалт хийх ажлыг эхэлнэ.
- ✓ Мониторинг үнэлгээний олон улсын зөвлөхийн эхлэлийн тайланд тусгагдсан төслийн үнэлгээний загварыг засаж сайжруулах, төслийн хэрэгжилттэй түлхүү уялдуулах тал дээр мониторинг үнэлгээний үндэсний зөвлөх ажиллаж байна. Мониторинг үнэлгээний үндэсний зөвлөх үнэлгээний арга зүйн төслийг боловсруулсан. Энэ баримт бичгийг эцэслэхээр ажиллаж байна. Үүнд төслийн А болон Б бүрэлдхүүн хэсгийн үнэлгээг ялгаатай авч үзэх, судалгааны түүврийн хэмжээг тогтоох зэрэг дээр нарийвчлан ажиллаж байна. Түүнчлэн мониторинг үнэлгээний үндэсний зөвлөх санхүүгийн боловсролын суурь ойлголтыг олон нийтэд олгох зорилготой телевизийн олон ангит киноны туршилтын ангийн үнэлгээний фокус бүлгийн ярилцлагын удирдамжийг боловсруулсан.
 - ✓ Мониторинг үнэлгээ үндэсний зөвлөхөөс санхүүгийн боловсрол олгох уран сайхны туршилтын кинонд үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж ТУХ-оор батлуулсан ба холбогдох тооцоог хийж Мониторинг үнэлгээний багт хүргүүлсэн.

4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ АЖЛУУД:

4.1. ХЗХ-дын чадавхийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:

1. ХЗХ-дын чадавхи бэхжүүлэх, сургалт зохион байгуулах,
2. ХЗХ-дод чадавхийн үнэлгээ хийх,
3. ХЗХ-дод эрх зүйн орчин, зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжөөр сургалт, хэлэлцүүлэг хийх,
4. ХЗХ-дын зохицуулалтын журам, зааварыг шинэчлэн боловсруулж батлуулах,
5. ХЗХ-дод газар дээрх иж бүрэн хяналт шалгалт болон үзлэг хийх,
6. ХЗХ-дод санхүү бүртгэлийн программ нэвтрүүлэх.

4.2 Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:

1. Телевизийн олон ангит киног бүтээх студийг сонгон шалгаруулах,
2. Телевизийн олон ангит уран сайхны киноны эхний туршилтын 2 ангит киног 3 студийр бүтээлгэх,
3. Киногоор иргэдэд хүрсэн мэдээлэл, мэдлэгийг үнэлэх,
4. Киног үргэлжлүүлэх шийдвэр гаргавал кино зохиол болон шалгарсан студитэй гэрээ байгуулж бусад 24 ангит киног бүтээлгэх,
5. ХЗХ-ны тухай баримтат кино хийх студи шалгаруулах, кино бүтээлгэх,
6. ХЗХ-ны зохицуулалт хяналт тохимол гаргах,
7. ХЗХ-дын үндэсний чуулга уулзалт зохион байгуулах,
8. Телевизийн шууд ярилцлага хийх, мэдээллийн хэрэгсэлээр иргэдийн ХЗХ-ны итгэлийг сэргээх мэдээлэл цацах

4.3 Төслийн удирдлага, зохион байгуулалт, мониторинг үнэлгээ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:

1. Төслийн удирдлага, хангамж
 - ✓ Төслийн зохицуулагчийг томилуулах,
 - ✓ Тоног төхөөрөмжийн худалдан авалтын ажиллагааг дуусгах
2. Мониторинг ба үнэлгээ
 - ✓ Уран сайхны туршилтын 2 ангид кинод мониторинг үнэлгээ хийх аргачлалыг боловсруулах,
 - ✓ Туршилтын кинод үнэлгээ хийх,
 - ✓ Чадавхийн үнэлгээний үеэр авсан ХЗХ-ын менежментийн "тэнхмийн" урьдчилсан сорил дээр үндэслэн бүх ХЗХ-ын чадавхийн түвшинг тогтоох суурь судалгаануудыг гаргах
 - ✓ Чадавхийн сургалтад үнэлгээ хийх аргачлалыг боловсруулах.

- ✓ СЗХ-ны улирлын тайлан дээр үндэслэн бүх ХЗХ-ын үйл ажиллагааны түвшинг тогтоох суурь судалгаануудыг гаргах
- ✓ СЗХ-ноос удирдан явуулсан иргэдийн санхүүгийн үйлчилгээний мэдлэг, салбар бүрийн санхүүгийн төлөв байдлын талаар хийсэн судалгаан дээр үндэслэн суурь мэдээллийг боловсруулах.

5.ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ

5.1. Худалдан авалтын төлөвлөгөө

60. Худалдан авалтын төлөвлөгөөг 2014 оны 2 дугаар сарын хуралдаанд танилцуулсан ба зарим өөрчлөлтийг оруулахаар худалдан авалтыг төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, 3 сард АХБ –д хүргүүлсэн.

61. Төслийн хүрээнд тоног төхөөрөмж худалдан авах техникийн үзүүлэлтийг боловсруулж, үнийн саналыг 5 газраас авсан.

62. Барааг АХБ-ны худалдан авах зааварчилга, журмын дагуу 5 байгууллагаас ирүүлсэн үнийн саналыг харьцуулан, хамгийн бага үнийн санал өгсөн, тавигдах шаардлага хангасан газрыг сонгож худалдан авалтыг хийхээр үнэлгээний хорооны дүгнэлтийг АХБ-д хүргүүлсэн.

63. АХБ-ны зөвшөөрлийн үндсэн дээр Номин ХХК, IT zon ХХК-тай гэрээ байгуулаад байна. Энэхүү худалдан авалтыг 4 сард хийж дуусгана

5.2.Төслийн хүрээнд хийгдсэн гэрээнүүдийн жагсаалт

64. Тайлант хугацаанд хийгдсэн бүх худалдан авалтын (бараа, ажил болон зөвлөх үйлчилгээ) гэрээний жагсаалтыг дор хүснэгтэд харуулав. Мөн гүйцэтгэгч байгууллага болон бусдаар санхүүжигдсэн гэрээнүүд багтсан бөгөөд холбогдох тайлбарыг тусгав.

Хүснэгт 1. Гэрээний жагсаалт

Ажлын нэр	Гэрээний дүн	Гэрээний тоо	Худалдан авалтын арга	Тайлбар
Олон ангит киноны зохиолч шалгаруулалт	25,000 USD	1	Энгийн худалдан авалт	Зохиолч А.Миеэгомботой гэрээ байгуулсан
ХЗХ-дод флаш диск худалдан авч өгөв	2,400,000	1	Энгийн худалдан авалт	ХЗХ-дод тараасан

1. СУРГАЛТ, СЕМИНАР, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТ

Хүснэгт 2. Тайлант хугацаанд зохион байгуулсан сургалт, семинар, хэлэлцүүлэг, уулзалт, хурал

Но	Нэр	Газар	Зардал (\$)	Оролцогчдын тоо	Хуваарь
----	-----	-------	-------------	-----------------	---------

No	Нэр	Газар	Зардал (\$)	Оролцогч-дын тоо	Хуваарь
Бүрэлдэхүүн хэсэг А: ХЗХ-ДЫН ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ; ЧАДАВХИЖУУЛАЛТ					
Бүрэлдэхүүн хэсэг А: ХЗХ-НЫ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ, СУРГАЛТ					
1	Интернетэд суурилсан сургалт	Хэнтий, Төв аймаг	9,215,340	75 оролцогч	2014 оны 1 дүгээр сарын 22
2	ХЗХ-ны сургагч багш бэлтгэх сургалт	Улаанбаатар зочид буудал	5,812,000	(7 орон нутаг)	2013.05.20-29
3	ХЗХ-дын чадавхи бэхжүүлэхУБ хотын 9 сургалт.	НАМАК, Монголын хоршоологчдын холбооны байр	32,068,850	196 ажилтан (46ХЗХ)	2014.02.21-2014.03.31

6. САНХҮҮ

Тайлант хугацаанд дараахь зардал гарсан болно.

6.1 Төслийн үйл ажиллагааны зардал

Хүснэгт 3. Зардлын хуваарилалт ба зарцуулагдсан зардал (2014 оны 3-р сарын 31-ны байдлаар)

№	Зардлын төрөл	Батлагдсан	Зарцуулагдсан
1. Шуудан, холбоо, интернетийн зардал			
1.1	Телефон утас	450,000.00	160,966.90
1.2	Интернэт	983,400.00	1,145,832.00
1.3	Буухиа шуудан	600,000.00	112,320.00
2. Бичиг хэргийн зардал			
2.1	Бичгийн цаас	1,020,000.00	448,800.00
2.2	Хувилагчийн хор	765,000.00	
2.3	Семинар хурлын ажиллагаанд	1,800,000.00	3,780,500.00
2.4	Бичгийн хэрэгсэл, хангамжийн зардал	4,500,000.00	1,144,775.00
3. Оффисын түрээс			
		6,375,000.00	2,953,440.00

4. Хот дотор унааны түрээс	1,500,000.00	761,800.00
Нийт	17,993,400.00	10,508,433.90

6.2 Төслийн урьдчилсан данс

65. Төслийн баг төслийн тусгай данс болон төслийн үйл ажиллагааны зардлыг зарцуулах дэд дансыг Төрийн банк дээр нээн үйл ажиллагааг тогтвортой явуулж байна.

Хүснэгт 9. Төслийн урьдчилсан сангийн данс (2014 оны 3-р сарын 31-ны байдлаар)

Дэд дансны баланс (MNT-34000372090)	199,494,318.21
Тусгай дансны баланс(USD-34000372080)	48,872.50
Үйл ажиллагааны дансны баланс (MNT-3400038460)	8,422,003.51
2014 оны 1-р улирлын нийт зарцуулалт (MNT)	107,237,380.86
Нийт нөхөн дүүргэлтийн дүн	0

Хүснэгт 4. Дэд болон тусгай данснаас зарцуулагдсан зардал

1	Зөвлөх үйлчилгээ	12,683,191.00
2	Цалин	18,720,826.86
3	Флаш	2,400,000.00
4	Багшийн хөлс	8,970,000.00
5	Туслах ажилтаны хөлс	220,000.00
6	Машины түрээс	3,292,200.00
7	Сургалтын заал, хоол, завсарлагааны цайны төлбөр	41,971,840.00
8	Болзошгүй зардал	31,050.00
9	Сургалтын материал олшруулсан төлбөр	4,506,500.00
10	Бичиг хэргийн зардал	4,484,410.00
11	Томилолт	5,466,000.00
12	Унааны зардал	1,155,000.00
13	Зар	1,836,363.00
14	Аудитын үйлчилгээ	1,500,000.00

107,237,380.86

66. Санхүүгийн тайланд 2014 оны 1-р улиралд гарсан зөвлөх үйлчилгээний төлбөрүүд, бараа худалдан авалт, сургалтын зарцуулалт, төслийн үйл ажиллагааны зардал нэг бүрийг тусган гаргаж сар, улирал тутамд СЯ, АХБ-нд гарган хүргүүлж байна.

6.3 Төслийн санхүүгийн тайлан

67. Төслийн санхүүгийн тайлан нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Үлдэгдэл баланс (Хавсралт 1)
2. Орлогын тайлан (Хавсралт 2)
3. Төслийн санхүүжилтийн тайлан (Хавсралт 3)
4. Төсөв ба гүйцэтгэлийн тайлан (Хавсралт 4)

68. Санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг үнэн зөв тусган гаргалаа.

Мөнгөн хөрөнгө

69. Төсөл нь төслийн жижиг мөнгөн сантай. Энэ сангаас өдөр тутмын үйл ажиллагаандаа бэлэн мөнгө ашиглаж байна.

70. Төслийн 2014 оны 3-р сарын 31-ний байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг харуулбал: Жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 3,560.00 төгрөг байна.

-----o0o-----